



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүн”

Хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулах шаардлагатай байна.

Аудитын код: ДГА-2021/75-ШТА-ГА

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг
2021 оны 07 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер:

У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ч.Ариунаа

Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Аудитор:

Д.Дэмбэрэлсүрэн

Цахим хаяг: demberelsuren.d@audit.gov.mn

Агуулга

Хүснэгтийн товъёог	4
Дүрслэлийн товъёог	4
Бүдүүвчийн товъёог	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Ерөнхий мэдээлэл	7
БҮЛЭГ А. Хүний нөөцийн бодлогоо шинэчилж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.	8
А.1 Стандартад нийцсэн орон тоог баталж, цомхон, хүний нөөцийг бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.	8
А.2 Ажил үүргийн хуваарилалт оновчтой байгаа эсэхэд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.	11
А.3 Ажлын гүйцэтгэлийг үнэлэн, улирал бүр урамшуулал олгож байгаа ч үнэлэх аргачлал нь тодорхой бус, ажилдаа шатлан дэвших нөхцөл бүрдээгүй байна.	13
БҮЛЭГ Б. Төсвийн төлөвлөлт нь бодит гүйцэтгэлд үндэслээгүй байна.	15
Б.1 Төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс удаа дараа төсвийн тодотгол хийгдэж, төсөвт нэмэлт өөрчлөлт орсон байна.	15
Б.2 Зарим зардалд төсвийн хэмнэлт үүссэн ч санхүүжилтгүйгээс зарцуулж чадаагүй байна.	20
Б.3 Төсөв захирагч төсвийн өмнө хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллуулаагүй байна.	23
БҮЛЭГ В. Тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд зөв зохион байгуулалт дутагдаж байна.	25
В.1 Хүний нөөц, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан ч хүчин чадалдаа хүрч ажиллаагүй байна.	25
В.2 Үйлчилгээгээ сайжруулах үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай байна.	27
БҮЛЭГ Г. Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	29
Г.1 Байгууллагын дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний багийн ажил хангалтгүй байна.	29
Г.2 Эрүүл мэндийн газраас өгсөн зөвлөмж, чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	30
Аудитын дүгнэлт	32
Аудитын зөвлөмж	33
Холбогдох байгууллагын санал	34
Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар	36
Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулсан тушаал	37

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГА	Гүйцэтгэлийн аудит
ДГА	Дорноговь аймаг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
НЭ	Нэгдсэн эмнэлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УТ	Улсын төсөв
ШТА	Шууд тайлагнах аудит
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДГ	Эрүүл мэндийн даатгалын газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЭТ	Эм эргэлтийн тасаг
ЯТТ	Яаралтай тусламжийн тасаг

Хүснэгтийн товъёог:

Утга	Тайлбар
Хүснэгт №1	Орон тооны мэдээлэл
Хүснэгт №2	Эмч сувилагчийн тоо
Хүснэгт №3	Сувилагчийн тоо
Хүснэгт №4	Бусад орон тоо
Хүснэгт №5	Орон тооны дэлгэрэнгүй
Хүснэгт №6	Алба хаагчдын үнэлгээ
Хүснэгт №7	Төсвийн төсөл, хянасан төсвийн харьцуулалт
Хүснэгт №8	Төсвийн төсөл, батлагдсан төсвийн зарим зардлын харьцуулалт
Хүснэгт №9	Санхүүжилтийн гүйцэтгэл
Хүснэгт №10	ЭМДС-ийн санхүүжилтийн гүйцэтгэл
Хүснэгт №11	Үйл ажиллагааны ашиг, алдагдал
Хүснэгт №12	Орон тооны бус ажилтны цалин хөлсний тооцоолол
Хүснэгт №13	Тасгуудын эм эмнэлгийн хэрэгслийн зардлын зарцуулалт
Хүснэгт №14	Эмийн үлдэгдэл, эмийн өглөг
Хүснэгт №15	Ор ашиглалт
Хүснэгт №16	Тоног төхөөрөмж

Дүрслэлийн товъёог:

Утга	Тайлбар
График №1	Орлогын төрлөөр хуваарилсан байдал
График №2	Нийт зарцуулалтыг зардлаар нь хуваарилсан байдал
График №3	Багцын тоо
График №4	Эмийн нэр төрөл
График №5	2019, 2020 оны төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт
График №6	Амбулаторийн үзлэг

Бүдүүвчийн товъёог

Утга	Тайлбар
Бүдүүвч №1	Эм зүйн албаны бүтэц

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын төлөвлөгөө батлах тухай” аудитын сэдвийг үндэслэн “Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүн”-д гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Боловсон хүчний бодлого оновчтой эсэх;
- Санхүүгийн үйл ажиллагаагаа үр дүнтэй удирдан зохион байгуулж байгаа эсэх;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хүртээмжтэй байгаа эсэх;
- Дотоод хяналтын үр дүнд үйл ажиллагаа сайжирсан эсэх.

Аудитын хамрах хүрээ

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын газрыг хамруулан гүйцэтгэлээ.

/аудитаар 2019, 2020, 2021 оны баримт материалыг суурь болгон хамруулна/

Аудитын хязгаарлалт

Цар тахал Covid-19 өвчлөлийн улмаас аймгийн Нэгдсэн эмнэлэг дээр очиж ажиллах боломжгүй, тодруулга тайлбар авах зарим ажилчид тусгаарлалтад орсон, зарим тооцоо судалгаа хийхэд цаг хугацаа их алдах зэрэг хязгаарлалтууд байсан.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-300, 3000-3100-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг үндэслэн гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулна.

**Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ган-Өлзий хянан удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Ч.Ариунаа, аудитор Т.Мөнхтогтох, аудитор Д.Дэмбэрэлсүрэн нар гүйцэтгэв.

Аудитын тайланг 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн дотор нэгтгэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар баталгаажуулж, дарга, тэргүүлэх аудиторын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар баталгаажуулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл

-

Ерөнхий мэдээлэл

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь “Бид нотолгоонд тулгуурлан оношилгоо, эмчилгээ, сувилгааны цогц үйлчилгээг шинэ мэдлэг, дэвшилтэт технологиор чанартай, тэгш хүртээмжтэй үзүүлнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааг явуулж байна.

Нэгдсэн эмнэлэг нь аймгийн хүн амд хоёр дахь шатлалын эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг 24 цагаар тасралтгүй үзүүлж, хэвтэн эмчлүүлэх хэсэгт хэвтүүлэн эмчлэх 9 тасагтай, /поликлиник/ амбулатори нь эмнэлгийн нарийн мэргэжлийн болон лаборатори, рентген, нөхөн сэргээх эмчилгээ зэрэг параклиникийн /лаборатори, дүрс оношилгоо/ кабинетуудаар тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Нэгдсэн эмнэлэг нь тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор нийт 6 удаа магадлан итгэмжлэлд хамрагдсан бөгөөд 2021 онд 3 жилийн хугацаагаар магадлан итгэмжлэгдсэн.

Тус эмнэлэг нийт 327.5 орон тоотой ажиллаж байгаа бөгөөд үүнээс удирдах ажилтан 1, их эмч 80, эм зүйч 2, сувилагч 99, эх баригч 12, бага эмч 3, туслах сувилагч 9, тусгай мэргэжилтэн 33, үйлчлэгч 39, бусад 49.5 ажилтан ажиллаж байна. Клиникийн профессор цолтой эмч 14, доктор 1, магистр, тэргүүлэх зэрэгтэй их эмч 13, эмнэлгийн мэргэжилтэн 16, ахлах зэрэгтэй их эмч 5, эмнэлгийн мэргэжилтэн 5 байна.

Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлдэг яаралтай тусламж үйлчилгээний тасаг 24 цагаар ажиллаж 2020 онд аймгийн төв болон алсын 8212 дуудлага хүлээн авсан байна. Үүнээс алсын 103 дуудлагад газар дээр нь очиж эмнэлгийн тусламж үзүүлж, осол гэмтлийн 157 дуудлага хүлээн авч эмнэлгийн түргэн тусламж үзүүлсэн байна.

Нэгдсэн эмнэлэг нь 2021 оны байдлаар хэвтэн эмчлүүлэх 218, өдрийн эмчилгээний 20, нийт 238 ор ашиглаж байгаа ба үүнээс 176 нь эрүүл мэндийн даатгалын сангаас, 48 нь улсын төсвөөс санхүүжиж, 14 орыг төлбөртэй үйлчилгээний хэлбэрээр ажиллуулж байна.

Нэгдсэн эмнэлэгт нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 56 хувь буюу 4212 нь аймгийн төвөөс, 44 хувь буюу 3284 нь сумын ЭМТ, сум дундын эмнэлгээс ирж хэвтэн эмчлүүлсэн байна.

Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив тусламжийн хүрээнд хийсэн эмнэлгийн барилга, ажлын байрны шинэчлэл:

- ЭМТ барилга /Нэгдсэн эмнэлгийн 2 дугаар байр/;
- ЭМТ барилга /50 ортой төрөх эмнэлэг/;
- Лабораторийн тасагт иж бүрэн тоноглолтой, биологийн аюулгүй кабинет;
- Ариутгалын тасагт иж бүрэн тоног төхөөрөмжтэй, шинэчлэгдсэн ажлын байр;
- Хог хаягдлын тасагт иж бүрэн тоног төхөөрөмжтэй ажлын байр;
- Мэс заслын тасагт вакуумжуулагдсан иж бүрэн хагалгааны өрөө;
- Цусны салбар төвд орчин үеийн тоноглолтой, ажлын байр.

Байгууллагын техник, технологийн шинэчлэл:

- Зөөврийн дижитал рентген аппарат;
- Суурин эхо аппарат;
- Гемодиализийн аппарат;
- Нян, антибиотик мэдрэг чанар тодорхойлох автомат систем;
- Цус өсгөврийн шинжилгээний автомат
- Автомат автоклав
- Эмнэлгийн хог хаягдлыг бутлагч төхөөрөмж;
- Жене эксперт;
- Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат.

БҮЛЭГ А. Хүний нөөцийн бодлогоо шинэчилж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

А.1 Стандартад нийцсэн орон тоог баталж, цомхон хүний нөөцийг бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.

А.1.1 Эмнэлгийн мэргэжилтэн, тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шууд оролцдог эмнэлгийн бусад мэргэжилтэн болон захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажилтны харьцаа алдагдсан байна.

Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг 2017 онд шинэчлэн баталсан байна. Тус стандартад эмнэлгийн тусламж үйлчилгээг үндсэн 13 чиглэлээр, мөн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, дэмжих үйлчилгээ гэсэн бүтцээр ажиллахаар тогтоож өгсөн байна.

Нэгдсэн эмнэлгийн бүтцийг авч үзвэл 2019 онд 269 орон тоогоор 12 тасаг нэгжтэй, 2020 онд 285 орон тоогоор 13 тасаг нэгжтэй, 2021 онд 327.5 орон тоогоор 15 тасаг нэгжтэй байхаар зохион байгуулсан байна.

Бүтэц, орон тоог MNS 5095:2017 стандарттай харьцуулж үзвэл:

MNS 5095:2017 стандартын А.1.1-д Эмнэлгийн тусламж, үйлчилгээг гардан үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтэн, тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шууд оролцдог эмнэлгийн бусад мэргэжилтэн болон захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажилтны харьцааг 70-75:30-25 байхаар тогтоож өгсөн. Гэтэл энэ харьцаа 67:33 буюу эмнэлгийн бусад мэргэжилтэн болон захиргаа аж ахуйн орон тоог илүү баталсан байна.

Орон тооны мэдээлэл

Д/д	Утга	Стандарт	2021 он		2020 он		Хүснэгт №1 2019 он	
			хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо
1	Эмнэлгийн мэргэжилтэн	70-75%	67	219.5	65	188	65	175
2	Эмнэлгийн бусад мэргэжилтэн болон захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажилтан	30-25%	33	108	35	97	35	94
Нийт			327.5	-	285	-	269	-

MNS 5095:2017 стандартын А.1.3-д Эмнэлгийн тусламж, үйлчилгээг гардан үзүүлж байгаа их эмч болон сувилагч (бакалаврын, дипломын, туслах)-ийн харьцааг 1:2.0-2.5 байхаар тогтоосон байна. Эмч сувилагчийн харьцаа 1.1-1.2 буюу сувилагчийн орон тоо стандартад хүрээгүй байна.

Эмч, сувилагчийн тоо

Д/д	Утга	Хүснэгт №2		
		2019	2020	2021
1	Их эмч	63	71	80
2	Сувилагч	77	81	99
	Харьцаа	1.2	1.1	1.2

MNS 5095:2017 стандартын А.1.4-т Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд гардан оролцож байгаа сувилагч (бакалаврын, дипломын) болон туслах сувилагчийн харьцааг 4:0.5-1-ээс багагүй байхаар заасан байна. Гэтэл туслах сувилагчийн орон тоог стандартын /доод хэмжээнээс/ 3-аар дутуу баталсан байна.

Сувилагчийн тоо

Хүснэгт №3

Д/д	УТГА	2019	2020	2021
1	Сувилагч	85	81	99
2	Туслах сувилагч	6	7	9
3	Байвал зохих туслах сувилагч	10	10	12

MNS 5095:2017 стандартын А.1.4-т “Лабораторийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эмнэл зүйн эмгэг судлалын эмч/лабораторийн эмч, био-анагаахын мэргэжилтэн болон эмнэлгийн тусгай мэргэжилтэн (лаборант/лабораторийн техникч)-ийн харьцааг 1:3-аас багагүй байна” гэсэн боловч 4/16 буюу лаборант стандартаас 4-өөр илүү байна.

MNS 5095:2017 стандартын А.6-д эмнэлгийн үндсэн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаатай холбоотой орон тоог тогтоож өгсөн байна.

Бусад орон тоо

Хүснэгт №4

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Байвал зохих доод орон тоо	Одоо байгаа /2021 он/
1	Эдийн засгийн төлөвлөлт, эрүүл мэндийн даатгал, санхүү, нягтлан бодох үйл ажиллагаа	4	10
2	Тусламж, үйлчилгээний дотоод хяналт (эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, дотоод халдварын хяналт, дотоод аудитын үйл ажиллагаа)	3	2.5
3	Хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаа	2	1
4	Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагаа (статистик мэдээлэл)	3	2
5	Сувилахуйн үйл ажиллагааны удирдлага ¹	2	2
6	Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа	2	0.5
7	Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ ²	2	0.5
8	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа (инженер:техникч)	4:2	2
9	Мэдээллийн технологийн үйл ажиллагаа	2	2
10	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа	1	0
11	Бичиг хэрэг, архивын үйл ажиллагаа	2	2
12	Эмнэлгийн аюултай хог хаягдлын менежмент	1	1
13	“Эмийн санд тавих нийтлэг шаардлага” стандартын дагуу хүний нөөцийг тооцно.	-	5

Тодруулбал: Эрүүл мэндийн даатгал хариуцсан ажилтан 3, нягтлан бодогч 3, нярав 3, эдийн засагчийн 1 орон тоо баталсан байна. Тогтоосон стандартаас тусламж, үйлчилгээний дотоод хяналт хариуцсан ажилтан 1, хүний нөөц удирдлага хариуцсан 1, нийгмийн эрүүл мэнд хариуцсан 1, судалгаа эрдэм шинжилгээ хариуцсан 1, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа хариуцсан 1 орон тоо тус тус дутуу байна.

¹ Тасагт ажиллаж байгаа ахлах сувилагч, арга зүйч сувилагчийг оролцуулж тооцоогүй бөгөөд зөвхөн ерөнхий сувилагчийг заасан.

² Эрдэм, шинжилгээний ажилтныг оруулаагүй бөгөөд үндсэн орон тоонд тусламж, үйлчилгээний тодорхой ачааллыг хуваалцаж ажиллахаар тооцов.

MNS 5095:2017 стандартын А.8-д эмнэлгийн удирдлага, дэмжих үйлчилгээний зарим албан тушаалын ажилтныг ажлын ачаалал, хэрэгцээ шаардлагатай уялдуулан гэрээгээр нэмэлтээр ажиллуулж болохоор заасан.

Гэтэл цахилгаанчин 2, сантехникч 5, механик 1, хоолны технологич 1, цахим бүртгэлийн ажилтан 3, үйлчлэгч 39 /асрагч/, мужаан 1 нийт 60 орон тоог үндсэн ажилтнаар ажиллуулсан байна.

Нэгдсэн эмнэлгийн төсөв, орон тоог Эрүүл мэндийн яамнаас баталдаг бөгөөд батлагдсан орон тоо, төсөвт багтаан үйл ажиллагаа явуулах ёстой.

Гэтэл байгууллагын даргын 2021 оны А/01 дүгээр тушаалаар бүтэц, орон тоог 327.5 аар баталсан байгаа нь ЭМЯ-ны хянасан орон тооноос 37.5-аар нэмсэн дүнтэй байна.

Орон тоог нэмж баталсан хэдий ч батлагдсан орон тоогоор бүрэн ажиллаж чадаагүй байна. Тухайлбал: 2021 онд 32 орон тоо сул, хүүхэд асрах чөлөөтэй 9 ажилтан, сурч байгаа 2 ажилтны орон тоонд хүн авч ажиллуулаагүй, ажил үүргийг хавсран гүйцэтгүүлж байна. Мөн батлагдаагүй орон тоон дээр 5 ажилтан авч ажиллуулж байна. Хүний нөөцийн мэргэжилтний өгсөн тайлбар судалгаагаар 6 ажлын байран дээр хүн авч ажиллуулах шаардлагагүй байгаа орон тооны хувьд хүрэлцээтэй, 22 нь сувилагчийн ажлын байр байгаа боловч сувилагч мэргэжилтэн дутмаг байна. Тухайн ажлын байран дээр шинээр төгссөн оюутнуудыг авч ажиллуулахаар ажлын захиалга өгч хүлээгдэж байна. Хүн авч ажиллуулах шаардлагагүй 6 ажлын байрыг орон тоо батлаагүй 5 ажлын байраар дахин сольж орон тоогоо батлах нь зүйтэй байна.

Орон тооны дэлгэрэнгүй

Хүснэгт №5

Батлагдсан орон тоо	Ажиллаж байгаа	Илүү орон тоогоор ажиллаж байгаа	Хүүхэд асрах чөлөөтэй	Сурч байгаа	Сул орон тоо	Хавсран ажиллаж байгаа
327.5	291	6	9	2	32	4

А.1.2. Зарим алба, тасгийн бүтцэд шинжилгээ хийж, стандарт журмаар заасан зайлшгүй шаардлагатай ажлын байрыг бий болгох шаардлагатай байна.

Нэгдсэн эмнэлэг нь 2019 онд 12, 2020 онд 13, 2021 онд 15 тасаг нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

MNS 5095:2017 стандартын 11.1-д эмнэлгийн тусламж үйлчилгээний бүтэц, үйл ажиллагааг тогтоож өгсөн байна. Стандартад заасны дагуу /2021 онд/ тасаг нэгжийн бүтцийг баталсан хэдий ч зарим тасгийн бүтцийг оновчтой зохион байгуулаагүй байна.

Стандартад заасан мэргэжлийн чиглэлийн орон тоог дутуу баталснаар үйл ажиллагааны стандартын хяналт, төлөвлөлт тал дээр ахиц бага гарч байна.

Үйл оношийн тасаг: Лаборатори, дүрс оношилгооны чиглэлийг нэгтгэн үйл оношийн тасаг нэртэйгээр бүтцийг зохион байгуулсан бөгөөд лаборатори 21, дүрс оношилгоо 10, нийт 31 орон тоог баталсан байна. Үүнээс лабораторийн хэсгийг авч үзвэл 4 эмч, 16 лаборанттайгаар 24 цагаар үйл ажиллагаагаа явуулж байна. Лаборатори нь 15 цагаас хойш яаралтай тусламж болон, тасгаар хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөнүүдийн яаралтай шинжилгээг гаргадаг


Стандартад лабораторийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эмнэл зүйн эмгэг судлалын эмч/лабораторийн эмч, био-анагаахын мэргэжилтэн болон эмнэлгийн тусгай мэргэжилтэн (лаборант/лабораторийн техникч)-ийн харьцааг 1:3-аас багагүй байна гэж заасан байхад 4 лаборантын орон тоог илүү баталсан байна.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас лаборант нар замын постод ээлжлэн гарч шинжилгээ авч байна. Лаборант нарын ажлын тайланг авч үзэхэд ажлын ачааллын хувьд хэвийн нөхцөл байдалтай байгаа нь цар тахалгүй хэвийн үед батлагдсан бүрэн орон тоогоор ажиллахад ажлын ачаалал буурах тул орон тоог бууруулж стандартын хэмжээгээр ажиллах зохистой юм.

Эм зүйн алба: Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/180 дугаар тушаалаар “Үлгэрчилсэн дүрэм”-ийг баталсан байна. Үлгэрчилсэн дүрмээр эм зүйн алба нь менежментийн баг, мэргэжлийн баг, дэмжих багаас бүрдэхээр заасан.

Менежментийн багт эм шинжээч, нөөцийн тасгийн эм зүйч байхаар заасан боловч дээрх албан тушаалыг бүтцэд оруулж батлаагүй байна.

Нөөцийн тасгийн эм зүйчийн орон тоог батлаагүйгээс эмийн нөөцийн тооцоо хийгдэхгүй байгаа нь эмнэлгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.



Чанарын алба: Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/566 дугаар тушаалаар чанарын албаны бүтэц үйл ажиллагаа, ажлын чиг үүргийг шинэчлэн баталсан. Уг тушаалаар чанарын алба 4 орон тоотой байхаар баталсан ч одоогийн бүтцээр 2 орон тоотой ажиллаж байна. Аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежер, тусламж үйлчилгээ, чанарын мэдээллийн асуудал хариуцсан эмнэлгийн мэргэжилтний орон тоог батлаагүй байна. Харин эрсдэл хариуцсан менежерийг 0.5 орон тоогоор баталж чанарын менежер давхар хариуцан ажиллаж байна.

А.2 Ажил үүргийн хуваарилалт оновчтой байгаа эсэхэд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна.

А.2.1 Ихэнх ажлын байрны тодорхойлолтыг шинэчлээгүй, зарим албан тушаалд ажлын байрны тодорхойлолт боловсруулаагүй байна.

MNS 5095:2017 "Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа" стандартын А.6.2-т “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан үлгэрчилсэн загварын дагуу ажлын байрны тодорхойлолтыг байгууллагын бүх албан тушаал, мэргэжлээр гаргаж, өөрчлөлт ороогүй тохиолдолд 3 жил тутамд, өөрчлөлт орсон тухай бүрд шинэчлэн, шинээр тасаг, нэгж, ажлын байр үүссэн тухай бүрд шинээр боловсруулан баталгаажуулна” гэж заасан.

Аудитаар 95 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг хамруулж үзсэн бөгөөд 78 тодорхойлолт шинэчлэгдээгүй, ихэнх ажлын байрны тодорхойлолтыг 2009-2013 онд боловсруулсан бөгөөд дахин шинэчлээгүй байна.

Ажлын байрны тодорхойлолтыг тухайн мэргэжлийн онцлогт тохируулан боловсруулаагүй, эмч, сувилагч, асрагч гэх мэт мэргэжлийн нэршлээр нийтлэг байдлаар боловсруулсан байна.

Тухайн ажлын байрны чиг үүргийн шинжилгээг хийгээгүй, хууль тогтоомж, стандартад заагдсан чиг үүргүүд бүрэн хуваарилагдсан эсэх, ажлын байрны давхардал байгаа эсэхийг тодруулаагүй байна. Мөн ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй ажил үүргийг гүйцэтгэдэг, ажил үүргийн зөв зохион байгуулалт хийгээгүйгээс зарим ажлын байрны үндсэн чиг үүрэг орхигдсон байна. Тухайлбал:

- Эмзүйн албаны дарга, клиник эм зүйчийн ажлын байрны тодорхойлолтод эмчийг эмийн эмчилгээтэй холбоотой мэдээллээр хангах, эмнэлгийн эмийн эмчилгээний хорооны ажлыг хариуцах, эмнэлгийн эмийн хэрэглээнд хяналт тавих, эмийн гаж нөлөөг илрүүлэх, илэрсэн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, гаж нөлөөг үнэлэх асуудлыг эмчтэй хамтарч шийдвэрлэх зэрэг чиг үүргийг тусгасан боловч ажлын тайланд тодорхой хийгдсэн ажил байхгүй, ихэнх цагийг эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахад зарцуулсан байна.
- Хүний нөөцийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, тайлагнах, хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, сул орон тоог нөхөх, ажилтныг мэргэжил албан тушаалын хувьд ахиулах төлөвлөлт /карьер/-ийг ойрын болон дунд хугацаагаар хийх зэргээр заасан ч ажилчдын ээлжийн амралтыг олгох, богино хугацааны чөлөө олгох, судалгаа гаргах зэрэгт ихэнх цагийг зарцуулж, хүний нөөцийн бодлого боловсруулах чиг үүрэг орхигдсон байна. Энэ нь хүний нөөцийн албан тушаал дээр стандартад заагдсан орон тоогоор ажиллуулаагүй мөн сүүлийн 3 жилд 4 хүний нөөцийн ажилтан солигдсон зэргээс шалтгаалж ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулаагүй, хүний нөөцийн урт болон богино хугацааны бодлого төлөвлөлт бүрэн хийгдээгүй байна.
- Эд хариуцагчийн нэмэгдлийг нийт 9 арга зүйч сувилагчид олгож байгаа ч ажлын байрны тодорхойлолтод чиг үүргийг тусгаагүй.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг боловсруулаагүй байна.

A.2.2 Тухайн ажлын байрны хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй байна.

MNS 5095:2017 "Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа" стандартын А.6.2-т "Эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай, чанартай үзүүлэхэд шаардлагатай эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэн, ажилтны хэрэгцээг тооцож, сул орон тоог нөхөх, ажилтныг мэргэжил, албан тушаалын хувьд ахиулах төлөвлөлт (карьер)-ийг ойрын болон дунд хугацаагаар хийж, эмнэлгийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан хэрэгжүүлнэ" гэж заасан.

Нэгдсэн эмнэлгийн даргын 2021 оны А/01 тоот тушаалаар байгууллагын удирдлага, менежмент бодлого зохицуулалт, ариутгалын тасаг, дэмжин туслах алба, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хэсэг, эрчимт эмчилгээний тасаг, яаралтай тусламжийн тасаг, үйл оношийн тасаг, амбулаторийн тасаг, хөнгөвчлөх, хими эмчилгээний тасаг, цусны салбар төв гэсэн бүтцээр ажиллахаар баталсан байна.

Ажлын байрны хэрэгцээ шаардлагыг тооцоход зарим ажлын байрны орон тоог 0.5-аар баталж ирсэн бөгөөд хавсран болон хослон ажиллуулах тушаал гаргаж тухайн чиг үүргийг гүйцэтгүүлж байна. Тухайлбал:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны орон тоог баталсан ч ажилчдын эрүүл мэнд хариуцсан чиг үүргийг хариуцуулалгүйгээр дахин 0.5 орон тоогоор ажилчдын эрүүл мэнд хариуцсан ажилтны албан тушаал баталсан.
- Эрүүл мэндийн сайдын тушаалаар чанарын албаны бүтцэд эрсдэлийн менежерийг ажиллуулахаар заасан байхад 0.5 орон тоогоор батлан чанарын менежер давхар чиг үүргийг хариуцаж байна.
- Хордлогын их эмчийн орон тоог батлаагүй байхад хавсран ажилласны нэмэгдэл 20 хувь олгосон /ажлын байрны тодорхойлолтоор хариуцуулах боломжтой/
- Хоол зүйч эмчийн орон тоог 0.5-аар батлан дотрын их эмчээр хавсран гүйцэтгүүлсэн байна.

Хагас орон тоогоор буюу 0.5 орон тоогоор баталсан ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэлгүй хавсран ажилласны нэмэгдлийг авсан байна.

Эмнэлгийн дэмжих, туслах албаны бүтцийг зөв зохион байгуулаагүйгээс мэргэжлийн ажилчдын орон тоог хязгаарлахад хүргэсэн байна.

Тухайлбал:

- Цахилгаанчин -2;
- Мужаан-1;
- Сантехникийн слесарь, гагнуурчин-1;
- Сантехникийн слесарь-4;
- Жолооч-6 орон тоо баталсан, ажлын байрны хэрэгцээ шаардлага, ажлын ачаалал зэргийг тооцож үзээгүй байна.

А.3 Ажлын гүйцэтгэлийг үнэлэн улирал бүр урамшуулал олгож байгаа ч үнэлэх аргачлал нь тодорхой бус, ажилдаа шатлан дэвших нөхцөл бүрдээгүй байна.

А.3.1 Ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлалыг нарийвчлан тогтоох шаардлагатай байна.

Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох” журмыг баталсан бөгөөд төсвийн шууд захирагч журамд нийцүүлэн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох нарийвчилсан журмыг баталж болно гэж заасан байдаг. Нэгдсэн эмнэлгийн даргын 2020 оны 03 сарын 17-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар "Нэгдсэн эмнэлгийн ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх, мөнгөн урамшуулал олгох журам"-ийг баталсан байна.

Батлагдсан журмын хүрээнд улирал бүр үр дүнг үнэлэн 2019 онд 123.6 сая төгрөгийн, 2020 онд 305.2 сая төгрөгийн, 2021 оны 1 дүгээр улиралд 75.5 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгожээ. Үнэлгээг авч үзэхэд 90-100% үнэлэгдсэн албан хаагчийн тоо 4 дүгээр улиралд 85-аар нэмэгдсэн, 0-71% үнэлэгдсэн албан хаагчийн тоо буурсан байгаагаас харахад ажлын үр дүн, бүтээмж нэмэгдсэн үзүүлэлт харагдаж байна.

Алба хаагчдын үнэлгээ

2020 он	Хүснэгт №6		
	90-100%	71-89%	0-71%
1 улирал	161	102	51
2 улирал	194	60	60
3 улирал	201	63	50
4 улирал	246	22	46

“Нэгдсэн эмнэлгийн ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх, мөнгөн урамшуулал олгох журам”-ыг баталсан хэдий ч шалгуур үзүүлэлтийг ямар аргачлалаар үнэлэх нь тодорхойгүй байна. Тухайлбал: Үйлчлүүлэгч, хамт олны сэтгэл ханамжийн байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлт тогтоосон ч хамт олны сэтгэл ханамжийг хэрхэн, юугаар тодорхойлж байгаа нь тодорхой бус, ёс зүй харьцааны байдал, ажлын цаг ашиглалт, үйлчлүүлэгчид зөвлөгөө өгсөн байдал зэргийг ч хэрхэн яаж үнэлэх нь ч тодорхой бус байна.

Цаашид иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанар, сэтгэл ханамжийн үнэлгээнд үндэслэн үнэлэх аргыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Мөн эмнэлгийн тусламж үйлчилгээнд оруулсан хувь нэмрийг үнэлэхдээ шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлсэн байдал, үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал санаачилга гаргасан байдлыг харгалзан үзэлгүйгээр үнэлж, үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгож байгаа нь мэргэжилдээ өсөж дэвших, шинэ санал санаачилга гаргах зэрэгт сөргөөр нөлөөлж болзошгүй байдлыг бий болгосон байна.

А.3.2 Гүйцэтгэлийн үр дүнтэй уялдсан цалин нэмэх, албан тушаал дэвшүүлэх талаар дотоод журамд тусгаагүй байна.

MNS 5095:2017 "Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа" стандартын А.6.2-т “Ажлын байрны тодорхойлолтод үндэслэн ажилтан болон ажил олгогч хамтран ажилтныг жил бүр үнэлэх бөгөөд үнэлгээний дүнг бичгээр баталгаажуулан хувийн хэрэгт нь хадгална. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг харгалзан ажилтныг шагнаж урамшуулах, цалин нэмэх, албан тушаал дэвшүүлэх ажлыг ил тод зохион байгуулж, алдааг арилгах, сэргийлэх, ололт амжилтыг нийтийн хүртээл болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэж заасан.

Нэгдсэн эмнэлгийн даргын 2021 оны А/07 дугаар тушаалаар “Байгууллагын дотоод журам”-ыг шинэчлэн баталсан байна. Уг журамд улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох, бусдаас өндөр бүтээмж, мэргэжлийн ур чадвар гарган хүний амь нас аварсан, төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн ажилтанд урамшуулал олгохоор заасан байна.

Харин ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг харгалзан цалин нэмэх, албан тушаал дэвшүүлэх талаар тодорхой заалт тусгаагүй байв. Энэ нь мэргэжлээрээ өсөн дэвшихийг хязгаарласан, шинэ санал санаачилга гарсан эсэхээс үл хамааран бүгд ижил дүгнэгдэх үндэслэлийг бий болгосон байна.

БҮЛЭГ Б. Төсвийн төлөвлөлт нь бодит гүйцэтгэлд үндэслээгүй байна.

Б.1 Төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс удаа дараа төсвийн тодотгол хийгдэж, төсөвт нэмэлт өөрчлөлт орсон байна.

Б.1.1 Эрүүл мэндийн яам нь төсвийн төсөлд тусгасан саналыг харгалзаж үздэггүй байна.

Нэгдсэн эмнэлэг нь 2019, 2020 оны төсвийн төслийг удирдамжийн дагуу боловсруулан аймгийн Эрүүл мэндийн газарт Төсвийн тухай хуульд заасан хугацаанд³ хүргүүлсэн байна.

ЭМЯ-аас төсвийн төслийг хянахдаа 2019 онд 1,434.6 сая төгрөгөөр бууруулан 6,508.8 сая төгрөгөөр, 2020 онд 2,945.1 сая төгрөгөөр бууруулан 7,844.4 сая төгрөгөөр тус тус баталсан байна. /Хүснэгт №/

Төсвийн төсөл, хянасан төсвийн харьцуулалт

/сая.төг/				Хүснэгт №7
Д/д	Он	Төсвийн төсөл	Хянасан төсөв	Зөрүү
1	2019 он	7,943.4	6,508.8	1,434.6
2	2020 он	10,789.5	7,844.4	2,945.1

Төсвийн төслийг бэлтгэхдээ өмнөх он болон тухайн оны хүлээгдэж буй гүйцэтгэл, тасаг нэгжүүдээс ирүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга зэрэгт үндэслэн төлөвлөдөг боловч ЭМЯ зарим зардлыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн хянаагүй байна. Мөн төсвийг бодитой хянаж батлаагүйгээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эм эмнэлгийн хэрэгслийн зардал хүрэлцэхгүй их хэмжээний өр үүссэн, төсөвт 2019 онд 2 удаа, 2020 онд 5 удаа нэмэлт зохицуулалт хийгдсэн байна.

2020 онд хийгдсэн төсвийн тодотголыг тодруулбал:

- 2020 онд 50 ортой Төрөх эмнэлгийн тогтмол зардалд 113.4 сая төгрөг /УТ-ийг нэмэгдүүлсэн/;
- Нэмэгдэл цалин, тогтмол зардалд 103.5 сая төгрөг /ЭМДС-г нэмэгдүүлсэн/;
- Мэдээл технологийн үйлчилгээний төлбөрт 18.5 сая төгрөг /УТ-ийг нэмэгдүүлсэн/;
- Цалин нэмэгдэл урамшуулал, тогтмол зардал, эм эмнэлгийн хэрэгслийн зардал, урсгал засварын зардалд 288.5 сая төгрөг /УТ, ЭМДС-г нэмэгдүүлсэн/;
- Эм эмнэлгийн хэрэгслийн зардалд 493.5 сая төгрөг /УТ-ийг нэмэгдүүлсэн/.

2019 онд төсвийн төслийг 1,434.6 сая төгрөгөөр бууруулж батлахад 436.9 сая төгрөгийн өглөг үүссэн, 2020 онд төсвийн төслийг 2,945.1 сая төгрөгөөр бууруулж батлахад 183.8 сая төгрөгийн өглөг үүссэн байгаа нь төсвийн төслийн дүн хэт өндөр, бодитой биш хийгдсэн гэж үзэж болохоор байна.

/Хүснэгтэд төсвийн төсөл, хянасан төсвийн зөрүү харуулав/

³ 8.4.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг ТТЗ-д харьяалагддаг ТШЗ нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах ТТЗ-д хүргүүлэх.

Төсвийн төсөл, хянасан төсвийн зарим зардлын харьцуулалт

/сая.төг/

Хүснэгт №8

Д/д	Үзүүлэлт	2019 он			2020 он		
		Төсвийн төсөл	Хянасан	Зөрүү	Төсвийн төсөл	Хянасан төсөв	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,754.6	3,653.6	101.0	5,523.4	4,357.3	1,166.1
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	450.6	456.7	-6.1	745.7	588.2	157.5
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,173.8	749.8	424.0	1,345.0	933.8	411.2
4	Хангамж, бараа материалын зардал	357.1	118.4	238.7	344.1	131.9	212.2
5	Нормативт зардал	1,645.5	1,405.1	240.4	2,288.7	1,703.4	585.3
6	Эд хогшил, урсгал засварын зардал	238.9	71.1	167.8	267.4	71.1	196.3
7	Бусад урсгал шилжүүлэг	269.0	5.1	263.9	217.8	5.4	212.4

Өглөг үүссэн зардлууд:

- 2019 онд НДШ-ийн өглөг 12.0 сая төгрөг, цэвэр бохир усны өглөг 49.3 сая төгрөг, түлш халаалтын өглөг 94.0 сая төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн өглөг 281.6 сая төгрөг;
- 2020 онд нэмэгдэл урамшууллын өглөг 18.7 сая төгрөг, түлш халаалтын өглөг 78.8 сая төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн 86.3 сая төгрөгийн өглөг тус тус үүссэн байна.

Мөн 2021 онд 11,316.9 сая төгрөгийн төсвийн төслийн санал хүргүүлснээс 2,514.8 сая төгрөг буурч, 8,802.1 сая төгрөгийн төсөв батлагдсан. Үүнээс цалин хөлс 625.5 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 113.1 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 45.2 сая төгрөг, нормативт зардал 1,383.4 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 126.5 сая төгрөгөөр буурч батлагдсан байна.

Б.1.2 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих үйл ажиллагаа төлөвлөсөн хэмжээнд хийгдээгүйгээс санхүүжилтийн эх үүсвэр дутуу бүрдсэн байна.

Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1⁴-д заасны дагуу улсын төсөв /төр хариуцах/, эрүүл мэндийн даатгалын сан, төлбөртэй ажил үйлчилгээний орлогоос санхүүжсэн байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг авч үзэхэд /2020 он/ улсын төсвийн санхүүжилт 51 хувийг /4,538.6 сая/, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 46 хувийг /4,049.3 сая/, үндсэн үйл ажиллагааны орлого 3 хувийг /273.9 сая/ тус тус эзэлж байна.

Санхүүжилтийн гүйцэтгэлийг авч үзэхэд улсын төсвийн санхүүжилтийг бүрэн авсан бөгөөд, 2019 онд үндсэн үйл ажиллагааны орлого 3.2 сая төгрөгөөр давж биелсэн бол 2020 онд 8.3 сая төгрөгөөр тасарсан, 2020 онд ЭМДС-аас авах санхүүжилт 409.3 сая төгрөгөөр тасарсан байна. /Хүснэгтэд батлагдсан төсөв, гүйцэтгэлийн зөрүүг харуулав/

⁴ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, Засгийн газрын тусгай сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээ, бусад үйл ажиллагааны орлого, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Санхүүжилтийн гүйцэтгэл

/сая.төг/

Хүснэгт №9

Д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	2019 он			2020 он		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Улсын төсвөөс	3,271.3	3,271.3	-	4,538.6	4,538.6	-
2	Эрүүл мэндийн даатгалын сангаас	3,223.9	3,223.9	-	4,049.4	3,640.1	409.3
3	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	155.1	158.3	-3.2	273.9	265.6	8.3
	Нийт	6,650.3	6,653.5	-3.2	8,861.9	8,444.3	417.6

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх /худалдан авах/ гэрээ байгуулдаг бөгөөд гэрээнд 7 чиглэлийн тусламж үйлчилгээг үзүүлэхээр гэрээ байгуулсан байна. Хүснэгтэд ЭМДС-ийн /2020 он/ төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүүг харуулав.

ЭМДС-ийн санхүүжилтийн гүйцэтгэл

/сая.төг/

Хүснэгт №10

Д/д	Тусламж үйлчилгээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Хэвтүүлэн эмчлэх туламж үйлчилгээ	1,822.2	1,606.8	215.4
2	Амбулаторийн тусламж үйлчилгээ	1,133.8	915.4	218.4
3	Оношилгоо, шинжилгээ	931.4	983.3	-51.9
4	Өдрийн эмчилгээ	121.5	83.6	37.9
5	Хөнгөвчлөх туламж үйлчилгээ	40.5	51.0	-10.5
	Нийт	4,049.4	3,640.1	409.3

Гэрээний хэрэгжилтийг авч үзэхэд хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ 88.1 хувьтай, амбулаторийн тусламж үйлчилгээ 80.7 хувьтай, оношилгоо шинжилгээ 68.8 хувьтай гарч, төлөвлөсөн хэмжээндээ хүрч ажиллаагүй байна. Энэ нь covid19 цар тахлын үед шаардлагагүй тохиолдолд эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхгүй байх зөвлөмж, чиглэл гарсантай холбоотой байна.

Мөн эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтээ авдаг бөгөөд нэхэмжилсэн дүнгээрээ санхүүжилтээ авч чадахгүй байх нөхцөл үүссэн байна. Тухайлбал: Нэхэмжилсэн дүнгээс 2019 онд 1167 хүний 22.8 сая төгрөг, 2020 онд 1347 хүний 61.3 сая төгрөг хасаж санхүүжүүлсэн байна.

Энэ нь ЭМД-д хамрагдаагүй, бичиг баримтын зөрчилтэй иргэнд үйлчилсэн, хэвтүүлэн эмчлэх үеийн оношилгоо, шинжилгээний төлбөрийг нэхэмжилсэн, даатгуулагчийг хэвтүүлэн эмчлэх үед өвчний түүхэнд бичигдээгүй эм тариаг үйлчлүүлэгчээр гаргуулж, түүнийг даатгалын сангаас нэхэмжилсэн зэрэгтэй холбоотой байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 оны 05 дугаар сарын байдлаар 1,666.5 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 2,087.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Б.1.3 Эмчилгээ, үйлчилгээний өртөг зардлыг тооцоогүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2019 онд 6,648.5 сая төгрөгийн, 2020 онд 8,438.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Дээрх санхүүжилтийг 15 тасаг нэгжид хуваарилан зарцуулжээ. /График №1/



Нийт орлогын 47.0 хувийг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнээс, 14.0 хувийг амбулаторийн тусламж үйлчилгээнээс, 21.0 хувийг үйл оношийн үйлчилгээнээс, 14.0 хувийг төр хариуцах үйлчилгээнээс, 4.0 хувийг гемодиализийн үйлчилгээнээс тус тус санхүүжсэн байна.

Нийт зардлыг тасаг нэгжид хуваарилан тооцвол дэмжих үйлчилгээ 4 хувийг, ариутгалын зардал тус бүр 5 хувийг, гемодиализын үйлчилгээ 5 хувийг, удирдлагын зардал 6 хувийг, амбулаторийн үйлчилгээний зардал 15 хувийг, үйл оношийн зардал 14 хувийг, хэвтүүлэн эмчлэх үйлчилгээний зардалд 51 хувийг тус тус зарцуулсан байна.

Тусламж үйлчилгээ тус бүрийн өртөг зардлыг тооцож үзэхэд ЯТТ-ийн үйлчилгээнээс 1,512.1 сая төгрөгийн санхүүжилт авч 352.9 сая төгрөгийг, үйл оношийн үйлчилгээнээс 1,737.3 сая төгрөгийн санхүүжилт авч 1,205.4 сая төгрөгийг зарцуулсан байгаагаас харахад дээрх 2 үйлчилгээ нь өртгөө бүрэн нөхөж, бусад тасаг нэгжийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүүхэд, мэс засал, төрөх, халдварт, эрчимт эмчилгээний тасгууд өртөг зардлыг бүрэн нөхөж чадаагүй 123.7-417.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. /Хүснэгтэд орлого, зардлын зөрүүг харуулав/

Үйл ажиллагааны ашиг, алдагдал

/сая.төг/		Хүснэгт №11					
		2019 он			2020 он		
Д/д	Тасгийн нэр	Нийт зардал	Нийт орлого	Зөрүү	Нийт зардал	Нийт орлого	Зөрүү
1	Амбулатори	1,129.8	1,218.8	89.0	1,227.7	1,206.4	(21.3)
2	Мэдрэл	252.4	262.2	9.8	338.5	286.2	(52.3)
3	Хүүхэд	310.3	302.2	(8.1)	427.0	303.3	(123.7)
4	Мэс засал	539.8	393.8	(146.0)	699.1	558.2	(140.9)
5	Төрөх	545.0	362.8	(182.2)	800.8	428.4	(372.4)
6	Халдварт	341.4	116.4	(225.0)	492.3	109.2	(383.1)
7	Эрчимт	456.0	78.9	(377.1)	557.9	140.7	(417.2)
Нийт		3,574.7	2,735.1	(839.6)	4,543.3	3,032.4	(1,500.9)

/Тайлбар: УТ-ийн санхүүжилтийг ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 тогтоолын тариф, өртөгийн жинг суурь болгосон/

График №2



Нийт зардлыг зардлын зүйлээр авч үзэхэд 2020 онд нийт төсвийн 54 хувийг цалин хөлс, 22 хувийг эм эмнэлгийн хэрэгсэл 12 хувийг тогтмол зардал, 10 хувийг бусад зардал, 2 хувийг бараа материалын зардал тус тус эзэлж байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:

Тайлант 2020 онд 4, 536.4 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал гарсан бөгөөд батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласнаар 18.7 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

Нэгдсэн эмнэлгийн стандарт MNS 5095:2017-д гэрээгээр гүйцэтгүүлж болох албан тушаалыг баталсан боловч ажлын ачаалал, ажлын байрны хэрэгцээ шаардлагыг тооцож үзэлгүй үндсэн орон тоогоор ажиллуулж ирсэн байна. Тухайлбал: Гэрээгээр ажиллуулж болох албан тушаалд 2020 онд 56.5 орон тоо баталж 430.8 сая төгрөгийн цалингийн зардал гарсан байна. /Хүснэгтэд харуулав/

Гэрээгээр гүйцэтгүүлж болох албан тушаалын цалин хөлсний тооцоолол					
/сая.төг/					
Д/д	Албан тушаал	Орон тоо	Цалин	Сар	Нийт
1	Аюулгүй ажиллагааны ажилтан	0.5	0.6	6	3.6
2	Механик /техникч/	1	0.8	12	9.6
3	Хоолны технологич	1	0.6	12	7.2
4	Мужаан	1	0.6	12	7.2
5	Цахилгаан	2	1.1	12	13.2
6	Цахим бүртгэлийн ажилтан	2	1.5	12	18.0
7	Сантехник	5	3.1	12	37.2
8	Тогооч	6	3.4	12	40.8
9	Үйлчлэгч	38	24.5	12	294.0
Нийт		56.5	36.2	-	430.8

Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал:

Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал 2019 онд 1,292.4 сая төгрөг байсан бол 2020 онд 599.9 сая төгрөгөөр нэмэгдэж 1,892.3 сая төгрөг болсон байна.

Нэг эмчлүүлэгчид ногдох эм, эмнэлгийн хэрэгслийн зардал дунджаар 2019 онд 86.1 мянган төгрөг, 2020 онд 106.8 мянган төгрөг болж 20.7 мянган төгрөгөөр буюу 19.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эмийн зардлыг тасгаар хуваарилан үзэхэд /2020 он/ гемодиализ эмчилгээний зардал 16.5 хувь, үйл оношийн зардал 26.7 хувийг эзэлж байна.

Тасгуудын эм эмнэлгийн хэрэгслийн зардлын зарцуулалт			
/сая.төг/			
Д/д	Утга	2019 он	2020 он
1	Дэмжих үйлчилгээ	-	1.5
2	Дархлаажуулалт, вакцин	-	2.9
3	Удирдлага	1.1	3.3
4	Цусны салбар төв	6.5	9.9
5	Хөнгөвчлөх	10.6	21.7
6	Сүрьеэгийн диспансер	18.9	33.1
7	Өдрийн эмчилгээ	23.6	33.2
8	Яаралтай тусламжийн тасаг	31.5	50.3
9	Үнэгүй эм /эндокринологи, сэтгэц, хавдар/	30.7	53.9
10	Амбулатори	29.8	56.2
11	Ариутгал	34.2	56.9
12	Мэдрэлийн тасаг	42.0	60.2
13	Халдвартын тасаг	20.5	67.6

14	Хүүхдийн тасаг	53.3	94.2
15	Төрөх тасаг	60.8	101.7
16	Эрчимт эмчилгээний тасаг	66.4	113.9
17	Дотрын тасаг	117.4	141.7
18	Мэс заслын тасаг	97.9	170.6
19	Гемодиализ эмчилгээ	213.6	314.1
20	Үйл оношийн тасаг	433.6	505.4
Нийт		1,292.4	1,892.3

Гемодиализийн эмчилгээний санхүүжилтийг төр хариуцдаг байсан бол ЭМДҮЗ-ийн 2021 оны 3 дугаар тогтоол батлагдсан гарснаар ЭМДС-аас санхүүжихээр журамлагдсан.

Тус журамд хэвлийн диализ нэг удаагийн оролтод 55.0 мянган төгрөгийн, гемодиализ нэг удаагийн оролтод 125.0 мянган төгрөгөөр санхүүжилтийг олгохоор болсон байна. Диализийн өртөг зардлыг тооцож байгаагүй бөгөөд аудитын явцад эм, хэрэгслийн зардлыг тооцоолоход 100.6 мянган төгрөг гарсан бөгөөд үүнд цалин хөлс, ашиглалтын зардал ороогүй тул өртгөө нөхөхгүй байх эрсдэлтэй байна.

Үйл оношийн тасаг нь 2019 онд 362,094 лабораторийн шинжилгээ хийж 561.9 сая төгрөгийн урвалж оношлуур, 2020 онд 312,291 лабораторийн шинжилгээ хийж 481.8 сая төгрөгийн урвалж оношлуур зарцуулсан байна. Шинжилгээний бодит өртөг зардлыг мөн л тооцоолоогүй байна.

Б.2 Зарим зардалд төсвийн хэмнэлт үүссэн ч санхүүжилтгүйгээс зарцуулж чадаагүй байна.

Б.2.1 Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан ч эмийн хэрэгцээг үндэслэлтэй тооцоогүй байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн 2019, 2020, 2021 оны худалдан авах ажиллагааг хамрууллаа.

ТБОНӨХБАУХАТХ-ын 7.1.1 дэх заалт, 8.11, 8.12, 8.13 дахь заалтыг үндэслэн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахдаа 15 хувийг ерөнхий гэрээгээр, 84 хувийг НТШ-ын аргаар, 1 хувийг шууд гэрээгээр худалдан авсан байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар захиалагчийн эрхийг Эрүүл мэндийн газарт шилжүүлсэн байна. Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар 5-7 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороог байгуулжээ. Үнэлгээний хороо аймгийн нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга, тоо хэмжээнд үндэслэн тендерийн баримт бичгийг боловсруулдаг байна.

Тендерийн багцыг дотоодод үйлдвэрлэсэн, импортоор орж ирсэн зэргээр ангилж багцалсан бөгөөд 2019 онд 36 багц, 2020 онд 55 багц, 2021 онд 48 багцад НТШ-ыг зохион байгуулсан байна.

График №3



График №4



Худалдан авах эмийн төрөл өсөөгүй байхад 2020 онд тендерийн багцыг 18-аар нэмэгдүүлсэн, хэт цөөн буюу 1-10 төрлийн эмийг багцалж тендер зарласан байгаа нь оролцогч ирэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Мөн ихэнх тендерт захиалагчийн төсөвт өртгөөс хэтэрсэн үнийн санал ирж, дахин зарлах шаардлага гардаг байна. Тухайлбал: Эхний сонгон шалгаруулалтаар 2019 онд буюу 22.2 хувь буюу 8 багц тендер, 2020 онд 33.3 хувь буюу 18 багц тендер хүчингүй болж дахин зарлагдсан байна. Тендерийг дахин зарлахад хугацаа алдаж, 2 дахь сонгон шалгаруулалтын дараа шууд гэрээ байгуулсан байна.

Тус байгууллагын эмийн зардал хүрэлцдэггүй, эмийн өглөг төдийлөн буураагүй, мөн жилийн эцэст эмийн үлдэгдэл их хэмжээний нөөцтэй гарсан байна.

Эмийн үлдэгдэл

сая.төг		Хүснэгт №14	
Огноо	Эмийн үлдэгдэл	Үүнээс тайлант онд нөөцөлсөн	Тайлант оны нөөц хувиар
2019	161.2	59.1	36.7
2020	296.1	134.8	45.5

Эмийн нөөцийг тооцвол 2019 онд нийт жилийн хэрэглээний 12.5 хувийг, 2020 онд 15.6 хувийг нөөцөлсөн, батлагдсан төсвийг хэтрүүлж өр үүсгэсэн байна.

Байгууллагын түвшинд эмийн хэрэгцээ шаардлагыг тооцох, нөөц бүрдүүлэх, өглөг бууруулахад чиглэсэн тодорхой ажил хийгдээгүй, эм эмнэлгийн хэрэгслийг их хэмжээгээр нөөцөлсөн байна. Тухайлбал 2020 онд 100-500 хүртэл ширхгийн үлдэгдэлтэй 163 нэр төрлийн 42.0 сая төгрөгийн, 1000-5000 хүртэл ширхгийн үлдэгдэлтэй 29 нэр төрлийн 57.6 сая төгрөгийн, 5000 дээш үлдэгдэлтэй 8 нэр төрлийн 30.0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг нөөцөлсөн байв.

Энэ нь эмийн нөөц хариуцсан мэргэжилтэн байхгүй, эм зүйч үндсэн ажлын зэрэгцээ эмийн нөөцийн ажилтны үүргийг давхар гүйцэтгэж байгаатай холбоотой байна. Мөн тасаг нэгжүүдээс тухайн онд шаардлагатай эм тарианы захиалгыг авч хэвшээгүй, нягтлан бодогч тооцоо судалгаа хийгээгүй явж ирсэнтэй холбоотой байна.

Б.2.2 Цар тахалтай холбоотойгоор зарим зардлын зарцуулалт өмнөх оноос өссөн байна.


Нэгдсэн эмнэлэг нь 2019 онд нийт 6,648.5 сая төгрөгийн, 2020 онд нийт 8,438.3 сая төгрөгийн төсвийг зарцуулж ажилласан байна.

2020 оны төсвийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад дотоод албан томилолт 4.6 сая төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 10.1 сая төгрөг, тээвэр шатахуун 14.5 сая төгрөгөөр бага төсөв зарцуулсан. Харин өмнөх оноос илүү зарцуулсан зардлыг доорх графикт харуулав.

2019, 2020 оны төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт

/сая.төг/

График №5



Хог хаягдал зайлуулах, ариутгал:

Хог хаягдлын зардал өмнөх оноос өссөн нь коронавируст халдварын тархалтаас сэргийлэх, тандалтаар ажиллах, тусгаарлан ажиглах байранд ойрын болон дам хавьтлуудыг хянан ажиллахад зарцуулсан хэрэглээ нөлөөлсөн байна.

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс:

2020 онд коронавируст халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах шаардлагаар тасаг нэгжүүдийг нүүлгэн шилжүүлэх, халдвартын тасгийг коронавируст халдварыг эмчлэхэд зориулж шинээр өрөө тасалгаа үүсгэхэд зориулж шаардлагатай материалын зардал нэмэгдсэн байна.

Коронавируст халдварын эсрэг цэвэрлэгээ үйлчилгээний материалын хэрэглээ өмнөх оноос нэмэгдсэн. 2019 онд давхардсан тоогоор 84 нэр төрлийн 6,655 ширхэг 12.2 сая төгрөгийн цэвэрлэгээний материал авсан бол 2020 онд давхардсан тоогоор 99 нэр төрлийн 10,737 ширхэг 14.5 сая төгрөгийн цэвэрлэгээний материал худалдан авсан байна.

Цахим эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээг хурууны хээгээр бүртгэхээр болж шинээр 2.0 сая төгрөгийн 16 ширхэг хурууны хээ уншигч худалдан авсан байна.

Урсгал засвар:

Урсгал засварын зардалд 2019 онд нийт 55.6 сая төгрөг, үүнээс автомашины сэлбэг хэрэгсэлд 4.9 сая төгрөг, эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд 37.7 сая төгрөг, барилгын болон сантехникийн урсгал засварт 13.0 сая төгрөг зарцуулсан. 2020 онд автомашины засвар сэлбэг хэрэгсэлд 6.9 сая төгрөг, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд 32.4 сая төгрөг, барилгын болон сантехникийн урсгал засварт 32.9 сая төгрөг зарцуулсан байна.

Хоол, хүнс:

2019 онд эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо 7810, ор хоног 52,020, дундаж ор хоног 6.6 байсан бол 2020 онд 7,529 үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэн эмчлүүлснээр ор хоног 51,429, дундаж ор хоног 6.8 байна. Хэдийгээр эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо өмнөх оноос 281-ээр буурсан ч дундаж ор хоног 0.2-аар нэмэгдсэн байгаа нь хоолны зардал өсөхөд нөлөөлөх нэг үзүүлэлт болсон байна.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн махны зардал 2019 онд нийт хүнсний материалын 40% (47,450.0 мянган төгрөг)-ийг эзэлж байсан бол 2020 онд 42.2% болж 2.2%-аар өссөн. Нэг кг үхрийн махны дундаж үнэ 2019 онд 8,252.60 төгрөг байсан бол 2020 онд 9,081.56 төгрөг болж дунджаар 828.96 төгрөг буюу 10%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Цэвэр, бохир ус:

2019 онд 41,180 м.куб цэвэр, бохир ус хэрэглэсэн төлбөрт 166.4 сая төгрөг нэхэмжилснээс 117.1 сая төгрөгийг барагдуулж, 49.3 сая төгрөгийг өглөгөөр тайлагнасан байна. 2020 онд 50 ортой Төрөх эмнэлгийн барилга ашиглалтад орсон 2020 онд нийт 41,164 м.куб цэвэр, бохир ус хэрэглэсэн төлбөрт 167.5 сая төгрөг төлсөн. Өмнөх оны өглөг 49.3 сая төгрөгийг төлж барагдуулсан нь төсвийн гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 2019 онд давхардсан тоогоор 273 ажилтанд 13.4 сая төгрөгийн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг, хор саармагжуулах бүтээгдэхүүнийг 126 хүнд 2019 онд 7.4 сая, 2020 онд 8.3 сая төгрөг олгосон байна.

Нэгдсэн эмнэлгийн даргын тушаалаар 2019 онд 3.6 сая төгрөг, 2020 онд 2.5 сая төгрөгийн эм акталсан бөгөөд акталсан эмийн 99% нь хүчинтэй хугацаа дууссан, 1% нь хагарсны улмаас актлагдсан байна.

Эмийн нөөцөд зайлшгүй шаардлагатай хангалтад бэлэн байх ёстой боловч хэрэглэх шаардлага гарахгүй хадгалагддаг эмүүд байдаг байна. Тэдгээр эмийн хугацаа дууссан, зарим нь 2-3 жилийн өмнө худалдан авалтынх байдаг тул эм ханган нийлүүлэгчид буцаах боломжгүй байдаг байна.

Тогтоосон жишиг хэмжээ байхгүй байгаагаас төсвийг үр нөлөөтэй зарцуулж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Б.3 Төсөв захирагч төсвийн өмнө хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй байна.**Б.3.1 Төсвийн хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.6 “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг байгууллагын удирдлага тодорхойлно” гэж заасан байдаг.

Нэгдсэн эмнэлгийн даргын тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг томилогдсон бөгөөд дотоод хяналтын төлөвлөгөөг боловсруулсан байна. Уг төлөвлөгөөнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн хяналт тусгагдаагүй байна.

Тасгуудын ахлах сувилагч хэрэгцээтэй бараа материал, эм хэрэгслийн захиалгыг нэгтгэн шаардах хуудас бичдэг байна. Нягтлан бодогч эм, эмнэлгийн хэрэгсэл, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зарцуулалтын тооцоог хийдэггүй, тогтоосон норм байхгүй явсаар иржээ. Нягтлан бодогч материалын зардлын тооцоог хийдэггүй зөвхөн орлого, зарлагын баримтад үндэслэн бүртгэлийг хөтөлж байгаа нь хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт алдагдахад хүргэсэн байна.

Б.3.2 Төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг программ хангамжийн тусламжтайгаар гүйцэтгэх боломж байна.

Нэгдсэн эмнэлэг нь санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ий “Acolous 4.0” программыг ашиглаж байна. Уг программ нь offline учир байгууллагын удирдлагын зүгээс программ хангамжаар хяналт тавих боломж байдаггүй. Эм эмнэлгийн хэрэгслийг эмч нь эмчилгээгээ бичээд, сувилагч нь эмчилгээгээ түүж, тасгийн эрхлэгчээр хянуулж, эмчилгээ эрхэлсэн орлогчоор батлуулдаг байна.

Өдөр тутам хэрэглэгддэг эмнэлгийн хэрэгслийг эмчилгээтэйгээ хамт цохуулж авдаг, мэс заслын хагалгаа, төрөх хагалгаа, унтуулга амбулаторийн захиас зэргийг сарын эхэнд олгодог бөгөөд тасаг бүрийн эм эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтад байгууллагын тооцооны нягтлан бодогч хяналт тавьж ажилладаггүй байна.

“Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд e-health программ нь 2016 оноос хэрэгжиж эхэлсэн байна. Тус программыг үйл ажиллагаандаа бүрэн ашигласнаар эмнэлгээр үйлчлүүлэгсдийн нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангахуйц эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан үүсэх, өвчний түүхийг цахим хэлбэрээр хөтлөх, нотолгоонд суурилсан эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар дээшилж, шаардлагагүй давтан шинжилгээний тоог бууруулж зардал хэмнэх, хүлээгдэл чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээ, эмч эмнэлгийн ажилтны ажлын гүйцэтгэлийг хянах, дүгнэх боломжийг бүрдүүлэх зэрэг давуу талтай байна.

Аудитын явцад e-health програмын ашиглалтын талаар Нэгдсэн эмнэлгийн сүлжээний инженертэй ярилцлага хийхэд: Нэгдсэн эмнэлгийн хувьд 2019 онд амбулаторийн модуль, 2020 онд тасаг, 103, эм, бараа материалын эхний модулийг ашиглаж байгаа бөгөөд e-health програмын сайжруулалт дутуу хийгдсэн, програмын талаар Улаанбаатар хотоос ирсэн ажилтан зааварчилгаа дутуу өгсөн, байгууллагын үйл ажиллагаанд ашиглахад хөрөнгө санхүү дутагдалтай зэргээс үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж чадахгүй байна гэсэн тайлбарыг өгсөн.

Улсын Нэгдүгээр төв эмнэлэг нь e-health программыг 95 хувийн ашиглалттай үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. Үйлчлүүлэгч заавал эмнэлэгт ирж цаг авалгүйгээр эмнэлгийн хүлээгдлийн мэдээг тухайн агшинд эмнэлгийн цахим хуудаснаас харж үйлчлүүлэх кабинетын өдөр цагийг сонгон утсаар захиалга авах боломжтой болсон байна.

Нэгдсэн эмнэлэг нь 2 сүлжээний инженертэй бөгөөд өдөр тутамдаа компьютерын ашиглалттай холбоотой, принтерийн эвдрэл гэмтлийг засварладаг. Эмнэлгийн Ehealth, тандалт шинжилгээ, вакцины gereg.mn, даатгалын health.gov.mn, статистикийн hinfo3.mn зэрэг программын ашиглалтын зааварчилгаа өгдөг байна. Төсвийн төсөлд программ ашиглалт сайжруулах талаар санал оруулж байгаагүй байна.

E-health программыг үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж ажиллах мөн аймгийн Чандмань Илч ХХК-ий төсвийн хөрөнгийн зарцуулалтын дотоод удирдлагын программ хангамжийг нэвтрүүлсэн сайн туршлагатай танилцаж, өөрийн байгууллагын дотооддоо нэвтрүүлэх боломжтой эсэхийг судалж үзэх шаардлагатай байна.

БҮЛЭГ В. Тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд зөв зохион байгуулалт дутагдаж байна.

В.1 Хүний нөөц, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан ч хүчин чадалдаа хүрч ажиллаагүй байна.

В.1.1 Хэвтэн эмчлүүлэгчийн орны тоог өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөөгүй, зарим тасгийн ор ашиглалт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/479 дүгээр тушаалаар аймгийн хэмжээнд 2020-2021 онд ашиглах орны дээд хязгаарыг тогтоож өгсөн байна. Аймгийн ЭМГ-ын даргын тушаалаар нэгдсэн эмнэлэгт ашиглах орны тоог хуваарилсан бөгөөд НЭ-ийн даргын тушаалаар 2019 онд 237, 2020 онд 232, 2021 онд 238 ор ашиглахаар тус тус төлөвлөсөн байна.

Орны тоог статистикч эмч, даатгалын эмч, эмчилгээ эрхэлсэн орлогч, эмнэлгийн дарга нарын бүрэлдэхүүнтэй төлөвлөдөг байна.

Дээрх онуудад 8 хэвтүүлэн эмчлэх тасагт 15 чиглэлийн ороор үйлчлэхээр төлөвлөсөн байна. Үүний 5 чиглэлийн орыг 2021 онд шинээр нэмж төлөвлөжээ. Тодруулбал:

- Хордлогын 1 ор;
- Чих, хамар, хоолойн 2 ор;
- Эрүү нүүрний 1 ор;
- Нярайн 5 ор;
- ЯТТЭЭТасагт хордлогын 1 орыг тус тус шинээр нэмсэн байна.

Орны ашиглалтыг авч үзвэл 2019, 2020 онуудад хүлээгдэл гараагүй бөгөөд зарим тасгийн ор ашиглалт 50 хувьд хүрээгүй байна. Тухайлбал: Сэтгэцийн чиглэлээр 10 ор төлөвлөж, ашиглалт 7.5 хувьтай, эрчимт эмчилгээний тасагт 4 ор төлөвлөж 20.4 хувьтай, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний тасагт 10 ор төлөвлөж, 26 хувьтай, төрөх тасагт 25 ор төлөвлөж, ашиглалт 44.1 хувьтай байна. Харин сүрьеэ, хүүхэд, дотор, мэдрэл, эмэгтэйчүүдийн тасгийн ор ашиглалтын хувь 52.2-84.7 хувьтай байна. Ор ашиглалтын хувийг доорх хүснэгтэд харуулав. /Хүснэгт №15/

Ор ашиглалт

Хүснэгт №15

Д/д	Тасгийн нэр	2019 он		2020 он	
		Орны тоо	Ор ашиглалт хувь	Орны тоо	Ор ашиглалтын хувь
1	Сэтгэц	10	7.7	10	7.5
2	Эрчимт	5	16.1	4	20.4
3	Хөнгөвчлөх	10	19.7	10	26
4	Сүрьеэ	10	63.9	11	52.2
5	Төрөх	20	67	25	44.1
6	Мэс засал	18	71.7	18	53
7	Халдварт	7	77.2	7	49.1
8	Хүүхэд	30	96.6	30	81.9
9	Дотор	43	99.7	44	75.2
10	Мэдрэл	23	103.5	23	84.7
11	Эмэгтэйчүүд	5	121	10	56.5

Орны тоог өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн оновчтой төлөвлөхгүй байгаагаас байвал зохих эмч, эмнэлгийн ажилтны орон тоо илүү байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.


В.1.2 Амбулаторийн тасгийн цаг ашиглалт харилцан адилгүй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны А/185, А/252 тоот тушаалаар батлагдсан эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал тооцох, хөдөлмөрийн норм, норматив тогтоох аргачлалыг баталсан байна.

Дээрх аргачлал батлагдсан гарснаас хойш эмнэлгийн мэргэжилтний ажлын ачааллыг тооцоогүй бөгөөд амбулаторийн үзлэгийн цагийг 15 минутаар тооцож байна.

Амбулаторийн тасаг нь 2019 онд 21 кабинетаар, 2020 онд 20 кабинетаар үзлэг хийхээр төлөвлөжээ.

Амбулаторийн үзлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзэхэд 2019 онд 131.2 мянган үзлэг хийж гүйцэтгэл 95.4 хувьтай, 2020 онд 108.1 мянган үзлэг хийж гүйцэтгэл 82.4 хувьтай байна.



Товлосон хугацаагаар өдөрт дээд тал нь 32 хүнд үзлэг хийх боломжтой тооцоо гарч байгаа бөгөөд чих, хамар, хоолой, нүд, мэдрэлийн тасаг өдөрт дунджаар 25-39 үзлэг хийжээ. Харин мэс засал, сүрьеэ, шүдний тасгууд өдөрт 22-23 үзлэг хийсэн бол гэмтэл, дотор, эмэгтэйчүүд, хүүхэд, зүрх судас, хавдар, халдварт, физик эмчилгээний тасгууд 2-20 хүртэлх тооны үзлэг хийсэн байна.

Хэвтэн эмчлүүлэгч, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгээр үйлчлүүлж буй иргэдэд цаг товлодоггүй бөгөөд товлосон 15 минутад багтаан үзлэгийг хийж байгаагаас үзлэг цагтаа багтахгүй байх, дараагийн үйлчлүүлэгчид хүлээгдэл үүсэх зэрэг хүндрэл бэрхшээл тулгардаг байна.

В.1.3 Нэгдсэн эмнэлгийн стандартад заасан тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан бөгөөд багажийн шинжилгээний тоо өссөн үзүүлэлттэй байна.

MNS 5095:2017 стандартаар нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг тогтоож өгсөн. Тус эмнэлэг шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна.

- Үндсэн мэргэжлийн тусламжид 111/2/ төрлийн тоног төхөөрөмж хэрэглэгдэхээс хангалт 98.1 хувь;
- Бусад тусламж үйлчилгээнд 90/8/ төрлийн тоног төхөөрөмж хэрэглэгдэхээс хангалт 91.9 хувь;
- Дэмжих үйлчилгээнд 39 тоног төхөөрөмж хэрэглэгдэхээс хангалт 100 хувь;
- Лабораторийн тоног төхөөрөмж 70/2/ хангалт 97.1 хувь;
- Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж 96/8/ 91.6 хувь;
- Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны тоног төхөөрөмж 100 хувь хангагдсан байна.

Багажийн шинжилгээний тоон үзүүлэлтийг авч үзвэл 2020 онд эхо, зүрхний ачаалалтай бичлэг, 24 цагийн ЭКГ, КТГ /компьютер томограф/ өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд 2 шатлалын эмнэлэгт хийгдэх шинжилгээ, оношилгоог бүрэн хийж байна.

Багажийн шинжилгээний тоон үзүүлэлт

Утга	Хүснэгт №16		
	2019 он	2020 он	Өөрчлөлт /+буурсан -өссөн/
Лаборатори	362,055	312,291	49,764
ЭХО	22,432	22,841	-409
ЭКГ	8,919	8,495	424
Зүрхний ЭХО	926	891	35
Зүрхний ачаалалтай ЭКГ	33	106	-73
24 цаг ЭКГ	59	118	-59
Рентген	26,565	22,720	3,845
Ходоодны дуран	1,007	812	195
КТГ	546	762	-216

В.2 Үйлчилгээгээ сайжруулах үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай байна.

В.2.1 Үйлчлүүлэгчид Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээний талаар мэдээ, мэдээллийг фэйсбүүк хаягаар өгч ажилласан байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар мэдээлэл, эмнэлгийн үйл ажиллагаа, тухайн цаг үеийн болон урьдчилан сэргийлэх үзлэг, иргэдэд боловсрол олгох сургалтын талаарх мэдээ мэдээллийг “Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг” фэйсбүүк пэйж хуудсаар хүргэж ажиллаж байна.

2019 онд орон нутгийн Dtv телевизийн “Эмч зөвлөж байна” нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөөний цагаар 12 эмч, ард иргэдэд мэдээлэл хүргэн ажилласан байна.

2019 онд ЕБС-ийн сурагчдад “Өсвөр үеийнхэнд тулгамдаж буй асуудлууд” сэдэвт сургалт, “Сувилахуйн нэг өдөр”, “Үйлчлүүлэгчид ээлтэй-сувилахуйн тусламж” үйлчилгээ сэдэвт Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан байна.

2020 онд коронавируст халдвар /covid19/-ын болзошгүй эрсдэлээс сэргийлэх онцгой бэлэн байдал зарласантай холбогдуулан олон нийтийг хамарсан сургалт сурталчилгааг хориглосонтой холбоотой мэдээ мэдээллүүдийг фэйсбүүк болон хүлээлгийн танхимын хэсэгт брошур, видео бичлэг зэргийг байршуулан мэдээллийг өгч ажилласан байна.

Аудитаар иргэд, олон нийтээс 8 асуулт бүхий асуулга бэлтгэж онлайнаар буюу Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар, Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан авлаа. Санал асуулгад нийт 131 хүн хамрагдсан байна.

Асуулгын дүнгээс харахад нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг 31 хувь нь фэйсбүүк, 18 хувь нь эмч ажилтан, 15 хувь нь очиж мэддэг, 6 хувь нь хүмүүсээс, 2 хувь нь вэб сайт, 28 хувь нь мэдээлэл авч чаддаггүй гэж хариулсан байна.

Мөн байгууллагын www.dornogovine.mn вэб сайтын ашиглалт хангалтгүй буюу 2020 оны 12 дугаар сараас хойш мэдээлэл оруулаагүй байна. Иймд албан ёсны вэб сайтаар мэдээллийг иргэдэд өгч байх, ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

В.2.2 Үйлчлүүлэгчдийн өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байна.

2019 онд улирал бүр буюу 4 удаа үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг авч нийт 3160 хүн хамруулсан байна.

2020 онд Чанарын албанаас хэвтэн эмчлүүлэгч болон амбулаторийн үйлчлүүлэгч нараас 2 удаагийн давтамжтайгаар 336 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгааг авсан байна. Хэвтэн эмчлүүлэгчид тасаг нэгжийн үйлчилгээнд сэтгэл ханамж сайн, харин амбулаторийн үйлчлүүлэгчид эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл, үзлэгийн цаг очер дугаар авах, хүлээгдэл чирэгдэлд сэтгэл ханамжгүй байсан байна.

Үйлчлүүлэгчдээс гарсан тулгамдаж байгаа асуудлуудыг байгууллагын албан хаагчдад танилцуулж, цаг товлох, үйлчилгээний мэдээллийг ил тод цахим хэлбэрт шилжүүлэх замаар хүлээгдлийг бууруулж, хөтчийн үйлчилгээнд чанарын алба хяналт тавьж ажилласан байна.

Иргэд, үйлчлүүлэгчдээс эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмчийн ёс зүйтэй холбоотой 2019 онд 10, 2020 онд 9 өргөдөл, нийт 19 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд тухай бүр шийдвэрлэж ажилласан байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг авч үзэхэд задлан шинжилгээнд оруулахгүй байх, камер шүүлгэх, өвчний түүх хуулбарлах, эмчид гомдол гаргах, үйлчлүүлэгчээс гаргасан эм, тарианы мөнгийг буцаан авах тухай өргөдлүүд байна.

В.2.3 Эмчилгээ, үйлчилгээгээ иргэдэд сурталчлан таниулах, цаг товлох үйлчилгээгээ сайжруулах, дугаарын хүлээгдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

Аудитаар иргэд, олон нийтээс 8 асуулт бүхий асуулга бэлтгэж онлайнаар буюу Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар, Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн фейсбүүк пэйж хуудсаар дамжуулан авлаа. Санал асуулгад нийт 131 хүн хамрагдсан байна.

Дүнг нэгтгэхэд иргэд, яаралтай үед эмнэлгийн тусламж үйлчилгээг авч чаддаггүй гэж судалгаанд оролцогсдын 64% нь хариулсан байна. Мөн эмч нарын харилцааны соёл, үзлэгийн хүлээгдэл их байдаг гэсэн хариултауд анхаарал татаж байна. Санал асуулгын дүнг доор харуулав.

Танд эмнэлгийн үйлчилгээ авахад тулгардаг бэрхшээл юу вэ гэсэн асуултад

- Цаг авахад-37 /28%/
- Дугаар авахад олон хоногийн дараалалтай-47 /36%/
- Эмч нарын харилцааны соёл муу-42 /32%/
- Бусад -5 /4%/

Та яаралтай үед аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйлчилгээг цаг алдалгүй авч чадаж байна уу гэсэн асуултад

- Тийм – 47 /36%/
- Үгүй – 84 /64%/

Та аймгийн Нэгдсэн эмнэлэгт хандсанаар өөрт тулгарч буй эрүүл мэндийн асуудлаа шийдвэрлүүлж чадсан уу гэсэн асуултад

- Тийм – 60 /46%/
- Үгүй – 26 /20%/
- Дараагийн шатлалын эмнэлэгт хандсан – 13 /10%/
- Хувийн эмнэлэгт хандсан – 32 /24%/ гэж хариулсан байна.

Харин дараах сэтгэгдлийг бичсэн байв: *Зарим сувилагч нарын хандлага муу, шүдний номер дутмаг, дотрын эмчээ нэмэх, шинжилгээгээ бүх цагт авдаг болох, дуудлага өгөөд удаж ирдэг, заавал цаг авч үйлчлүүлэх шаардлага тавьдаг гэсэн байв.*

БҮЛЭГ Г. Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Г.1 Байгууллагын дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний багийн ажил хангалтгүй байна.

MNS 5095:2017 стандартын хэрэгжилтэд дотоодын хяналт шинжилгээ, үнэлгээг багаар тогтмол хийж, гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахаар дээрх стандартад заасан.

Тусламж үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдал болон холбогдох тушаал шийдвэр, албан даалгавар, стандарт, эмнэл зүйн заавар, удирдамж, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, мөн үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн эрэлт, хэрэгцээ, өргөдөл гомдлын мөрөөр хяналт хийхээр стандартад заасан байна.

Нэгдсэн эмнэлгийн даргын 2020 оны Б/47,48,49 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг томилсон бол, 2019 онд дотоод хяналтын ажилтнаар халдвараас сэргийлэх хяналтын албаны дарга У.Отгонбаяр ажилласан байна.

Стандартад заасан дотоод хяналт хариуцсан албан тушаалыг батлаагүйгээс дотоод хяналт хангалтгүй байна.

Дотоод хяналт, шалгалтаар хүний нөөц, үйл ажиллагаа, эмнэлгийн тоног төхөөрөмж, мэс заслын тусламж үйлчилгээ, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, хэрэглээ, гемодиализийн тусламж үйлчилгээ, эмнэл зүй, эмгэг судлалын конференц, эмнэл зүйн лаборатори, рентген шинжилгээ, хэт аван шинжилгээ, дурангийн шинжилгээ, СТ, MRI шинжилгээ, төрөх тасаг, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг шалгахад 79 заалт бүхий хяналтын хуудсыг боловсруулсан байна.

Дотоод хяналтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзэхэд дээрх хяналтын хуудсаар хяналт тавьсан эсэх нь тодорхойгүй, хяналтын үр дүнд ямар зөвлөмжийг хэнд өгсөн тодорхой бус байна. Тайланд дурдсан ажлууд нь чанарын албаны хэрэгжүүлсэн чиг үүргүүдтэй давхардсан байна.

Мөн дотоод хяналтын баг 2020 онд эмнэлгийн цахилгаан шатны бэлэн байдал аюулгүй байдал, гемодиализийн тусламж үйлчилгээ, Covid-19 цар тахлын үеийн бэлэн байдалд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

Дотоод хяналтын баг нь орон тооны бус, үндсэн албан үүргийн зэрэгцээ хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд, тухайн онд өргөн хүрээг хамарсан хяналт хийхээр төлөвлөсөн байгаа нь хяналт-шинжилгээ үнэлгээний чанарт нөлөөлж, дорвитой үр дүн гараагүй байна.

Г.2.1 Эрүүл мэндийн газраас өгсөн зөвлөмж, чиглэлийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.4-т “Аймгийн эрүүл мэндийн газар нь харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих” гэж хуульчилсан байдаг.

ЭМГ-аас мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүргийн хүрээнд 2020 онд нийт 6 удаагийн албан бичгээр зөвлөмж, чиглэлийг хүргүүлсэн байна. Зөвлөмжид удирдлагын манлайлал, багаар ажиллах чадварыг сайжруулах, эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээ, дүрмийг чанд баримтлах, дотоод журам, хамтын гэрээг шинэчлэн мөрдүүлэх, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг батлан мөрдүүлэх, шинээр ажилтан авах журмыг баталж мөрдөх чиглэлийг хүргүүлсэн байна. Гэтэл дотоод журам шинэчлэн батлахаас бусад зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Мөн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх, эх барих эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээ, сувилахуйн тусламж үйлчилгээ, эм зүйн болон тоног төхөөрөмжийн чиглэлээр тус тус зөвлөмж хүргүүлсэн байна.

Цаг товлох үйлчилгээний цахим программ ашиглалтыг сайжруулах, өргөжүүлэхэд анхаарч ажиллах, хөтөч сувилагч нарын ажлын ачааллыг тооцох, амбулаторийн лавлах үйлчилгээний ил тод байдлын талаар туршлага судалж, үйлчилгээг сайжруулах зөвлөмжийг хүргүүлсэн байна. Дээрх зөвлөмжийн дагуу тодорхой ажил хийгдээгүй байна

Г.2.2 Мэргэжлийн байгууллагын хяналт хийгдээгүй байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2021.06.10-ны өдрийн 2/242 тоот албан бичгээр эмчилгээний чанарын хяналтын байцаагчийн орон тоо сул байснаас сүүлийн 3 жилд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдээгүй тухай тайлбарыг ирүүлсэн байна.

ДУГНЭЛТ

Эмнэлгийн тусламж, үйлчилгээг гардан үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтэн, тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шууд оролцдог эмнэлгийн бусад мэргэжилтэн болон захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажилтны харьцаа алдагдсан, сувилагч, туслах сувилагчийн орон тоо стандартад хүрээгүй, лаборант стандартаас илүү, зарим зайлшгүй шаардлагатай орон тоог батлаагүй. Дэмжих үйлчилгээ буюу төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын ачаалал, ажлын байрны судалгаа хийлгүйгээр үндсэн орон тоогоор ажиллуулсан байна.

Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлээгүй, зарим ажлын байранд тодорхойлолт боловсруулаагүй. Хослон болон хавсран гүйцэтгэж байгаа албан хаагчдын ажлын гүйцэтгэл хангалтгүй, ажлын байрны давхардал байгаа эсэхэд шинжилгээ хийгээгүй байна.

Ажлын гүйцэтгэлийн үр дүнтэй уялдсан цалингийн шатлал ахих, албан тушаал дэвшүүлэх дотоод журамдаа заагаагүй, мөн ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлал байхгүй байна.

Эрүүл мэндийн яам төсвийг бодитой хянаагүй, батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтээ бүрэн авч чадаагүй зэргээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эм эмнэлгийн хэрэгслийн зардал хүрэлцэхгүй их хэмжээний өр үүссэн, төсөвт олон удаагийн нэмэлт зохицуулалт хийгдсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээ төлөвлөсөн хэмжээндээ хүрээгүй, нэхэмжилсэн дүнгээр санхүүжилтээ бүрэн авч чадаагүй байна.

Эмийн нөөцийн тасгийн эм зүйчгүйгээс эмийн хэрэглээ, хангалт, хэрэгцээ шаардлага, нөөцийг бодитой тооцох ажил орхигдсон байна.

Ихэнх тасаг, нэгж үйлчилгээний өртгөө бүрэн нөхөж чадаагүй, эмчилгээ үйлчилгээний өртөг зардлыг тооцоогүй, эм эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын норм хэмжээг тогтоогоогүй, зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

E-health программыг үйл ажиллагаандаа бүрэн ашиглахгүй байгаагаас төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг программ хангамжийн тусламжтайгаар гүйцэтгэж чадахгүй байна.

Орны тоог өмнөх оны тоон мэдээ, гүйцэтгэл зэрэгт үндэслэн тооцоогүй, ор ашиглалт хангалтгүй байна.

Эмчилгээ, үйлчилгээгээ иргэдэд таниулах, цаг товлох үйлчилгээгээ сайжруулах, дугаарын хүлээгдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

Стандартад заасан дотоод хяналт хариуцсан албан тушаалыг батлаагүйгээс дотоод хяналт хэрэгжээгүй, Эрүүл мэндийн газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА Г.АНХБАЯР ТАНАА:

1. Хэлтэс тасгийн зохион байгуулалтад бүтцийн шинжилгээ хийх, зайлшгүй шаардлагатай орон тоог бий болгох, эмнэлгийн мэргэжилтэн болон тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шууд оролцдог эмнэлгийн бусад мэргэжилтэн болон захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажилтны харьцааг стандартад нийцүүлэн тогтоох.
2. Албан тушаалын тодорхойлолтыг ажлын байр тус бүрээр шинэчлэн боловсруулж, ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийж давхардлыг арилгах, хүний нөөцийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого боловсруулах.
3. Ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлал батлах, гүйцэтгэлд үндэслэсэн цалин хөлсийг ахиулах, шатлан дэвшүүлэх бодлого боловсруулах.
4. Эмчилгээ, үйлчилгээний өртгийг тооцох, зардал бууруулах тодорхой арга хэмжээ авах, эм эмнэлгийн хэрэгслийн норм хэмжээг тогтоож, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг сайжруулах.
5. Эмийн нөөц хариуцсан эм зүйчийн албан тушаалыг бий болгох.
6. E-health программын ашиглалтыг сайжруулах.
7. Хэвтүүлэн эмчлэх орны хэрэгцээ шаардлагыг бодитой тогтоох, түүнд тохирсон хүний нөөцөөр ажиллах.
8. Эмчилгээ, үйлчилгээгээ иргэдэд сурталчлан таниулах, цаг товлох үйлчилгээгээ сайжруулах, дугаарын хүлээгдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч ажиллах.
9. Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулж, ажлын байрыг бий болгох.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

<p>ДОРНОГОВЬ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ</p> <p>44105 Дорноговь аймаг, Сайншанд сум, 2 дугаар баг, Утас: (705) 2-23-82 И-мэйл: dornogovi_ne@yahoo.com</p> <p>2021.07.07 № 651</p> <p>танай _____ -ны № _____ -т</p>	<p>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА</p>
--	--

Санал хүргүүлэх тухай

“Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Бүртгэлийн А.1.1-д заасан Дэмжих, туслах үйлчилгээний албанд барилгын сантехникч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер засварчин, гал тогооны ажилтнууд, түргэн тусламжийн жолооч зэрэг ажилтнууд хамаарч, эмнэлгийн тусламж үйлчилгээг хэвийн явуулах нөхцлийг ханган ажилладаг. Манай эмнэлгийн барилга 5 блок хэсэгтэй, 75228 м3 эзэлхүүнтэй ба үүнд ээлжийн 4 сантехникч, 1 гагнуурчин ажиллаж хэвийн үйл ажиллагааг хангадаг, ковид-19 цар тахлын тусламж үйлчилгээний шуурхай байдлыг ханган Улаанбаатар хот руу өвчтөн тээвэрлэх, тусгаарлах байр эмнэлгүүдийн хог хаягдлыг зөөж устгахтай холбоотойгоор жолоочийн тоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага гарсан, эмнэлгийн гал тогоо нь хэвтэн эмчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ ҮЭХ-той байгуулсан хамтын гэрээний хэрэгжилтийг ханган ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор үдийн хоолоор үйлчилдэг болон бусад шалтгааны улмаас дэмжих, туслах албаны орон тоог бууруулах боломжгүй байна. Бид өмнө нь сантехникийн слесарийг улирлын гэрээт хэлбэрээр ажиллуулж байсан боловч мэргэжлийн тогтвортой байх зарчим алдагдан шугам сүлжээг эвдэх, зарим тасаг нэгжийн халаалтын горим алдагдуулсан зэрэг зөрчил доголдол гарч байсан.
2. Бүртгэлийн маягтын 7 дугаарт заасан E-health программд халдварт сүрьеэ, төрөх эмэгтэйчүүд, цус, цусан бүтээгдэхүүний тусламж үйлчилгээний оношийн код тусгагдаагүйгээс өвчтөний түүхийг цахим хэлбэрээр бичих боломжгүй үүнээс үүдээд эмийн орлого зарлагыг хянах боломжгүй юм. Мөн Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах эрүүл

мэндийн тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт төлбөрийн хэмжээг батлах тухай” 2021 оны 03 дугаар тогтоолтой уялдаагүй зарим оношийн бүлгийн задаргааг хүлээн авдаггүй. Программын талаар зохиогч байгууллагад хүсэлт тавьсан боловч төсөв хөрөнгөгүйгээс өөрчлөлт, шинэчлэлт хийж чадахгүй байна.

Дүгнэлтийн бусад заалтыг хүлээн зөвшөөрч байгаа болно.

Хүндэтгэсэн нь:

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.АНХБАЯР

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

1. Аудитын зөвлөмжийн хэсэгт тусгагдсан “Дэмжих албаны бүтцэд шинжилгээ хийж, шаардлагагүй орон тоог цөөлөх” гэсэн зөвлөмжийг хаслаа.
2. Аудитын зөвлөмжийн хэсэгт тусгагдсан “E-health программыг үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж ажиллах” гэсэн зөвлөмжийг “E-health программын ашиглалтыг сайжруулах” гэж заслаа.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/21

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3, 2.4, 2020 оны А/106 дугаар “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” тушаалын 18.9, 2021 оны А/28 дугаар “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргад зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргад хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Т.ГАН-ӨЛЗИЙ



010010148

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Ахлах аудитор:

Ч.Ариунаа

Аудитор:

Т.Мөнхтогтох

Аудитор:

Д.Дэмбэрэлсүрэн

ХЯНАСАН:

Аудитын менежер:

У.Оюунтүлхүүр

Дарга, тэргүүлэх аудитор:

Т.Ган-Өлзий

**АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.**